

10

СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Камзабаева М.С.

Орчин үед төрийн удирдлагын төвлөрлийг багасгах явдал улам бүр өсөж байгаа учраас тухайн дэвсгэр нутагт эдийн засгийн системийн харилцан уялдаа холбоог идэвхижүүлэх явдал чухал болж байна. Орон нутгийн байгууллагууд, хуучин холбооны засгийн газрын мэдэлд хамаарагддаг зохицуулалт, үйл ажиллагаатай холбогдох засаглалын шийдвэрлэх олон асуудлыг өөртөө авч байгаа бөгөөд түүний нэг чиглэл нь гадаад эдийн засгийн үйл ажиллагаа юм.

Зарим районуудын түвшинд энэ нь холбооны, бүс нутгийн, нутгийн захиргааны гадаад эдийн засгийн бодлого гэсэн үндсэн гурван чиглэлээр хэрэгжин биелж байна.

Иймээс хил орчмын районууд хөгжлийн стратеги төлөвлөгөөнд гадаад эдийн засгийн үйл ажиллагааг авч үзэхдээ онцгой анхаарал тавих ёстой. Тухайлбал, Алтайн бүгд найрамдах улсын Кош-Агач районы стратегийн төлөвлөгөөнд захиргааны хөрөнгө оруулалтыг урьдчилан бүрдүүлэх, районы давуу болон сул талуудыг үнэлэх, мөн хөгжлийн хэтийн төлөв байдлыг тодорхойлох зэрэг хөгжлийн үндсэн чиглэлүүд тусгагдсан юм. Энэ бүхний үндсэн нь дараах гурван төрлийн арга хэмжээг бүрдүүлж байна. Үүнд: нэгд, зайлшгүй чухал, хоёрт, магадлалын, гуравт, чухал асуудлын гэх мэт.

Зайлшгүй чухал арга хэмжээ нь хөгжлийн ямар ч хувилбарын хувьд заавал байх ёстой зүйл. Энд юуны урьд хөдөө аж ахуй, холбоо, боловсролыг дэмжих арга хэмжээнүүдийг оруулж болно.

Магадлалынхад: Зөвхөн бүс нутгийн захиргааны дэмжлэгтэй нөхцөлд энэхүү чиглэлийг авч хэрэглэнэ.

Чухал асуудлынх: Хэд хэдэн чиглэлээр асар өргөн хүрээг хамран хэрэгжүүлэх эдгээр зүйлүүд нь холбооны улс, бүс нутаг, орон нутгийн түвшинд хөрөнгө, хүчийг нэгтгэн төвлөрүүлэх замаар зөвхөн цогцолбороор иж бүрэн хэрэгжих арга хэмжээнүүд юм.

Хүснэгт 1

Арга хэмжээ	Хэрэгжих нь	Шийдвэрийг хүлээн авах түвшин	Тодорхой төслийн жишээнүүд
Зайлшгүй чухал	Ямар ч хувилбарын үед байнга сайжирч байна.	Орон нутгийн	Хөдөө аж ахуй, холбоо, боловсрол
Магадлалын	Бүс нутгийн захиргааны байр байдлаас хамаарна.	Бүс нутгийн	Аялал жуучлал, үйлдвэр хөгжүүлэх, нийгмийн хүрээний хөрөнгө оруулалт
Чухал асуудлын	Холбооны улсын байр байдлаас хамаарна.	Холбооны	Хятад дахь зам, МАПП, хий дамжуулах барилга байгууламж, хил орчмын худалдааны бүс байгуулах

Нэгдүгээр тохиолдол нь илүү зохимжтой. Сүүлийн үед район нь холбооны төрийн байгууллагууд болон бусад бүгд найрамдах улсуудын анхаарлын төвд орших боллоо. Үүний гол шалтгаан нь районы газар зүйн хосгүй сайхан байдалтай холбоотой бөгөөд энэхүү онцлог байдал нь дээр дурьдсан чухал асуудлууд бүхий арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх бололцоо олгож байна. Эдгээр хувилбаруудад Хятад дахь зам, МАПП, хий дамжуулах хоолойн барилга байгууламжууд, хил орчмын худалдааны бүс байгуулах зэрэг томоохон төслүүд тусгагдаж байна. Энэ нь нийгэм, эдийн засаг, хүн амын амьдралын хэвшилд үндсэн өөрчлөлт гаргахад хүргэнэ. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх нь районы нийгэм-эдийн засгийн байдал, улмаар бүгд найрамдах улсад төдийгүй Баруун-Сибирийн бүс нутагт бүхэлд нь, магадгүй Орос улсад түүний эзлэх байр, гүйцэтгэх үүргийг эрс өөрчилнө. Ийм эерэг нааштай өөрчлөлттэй холбогдож хүн амын амьжиргааны түвшин дээшилж ажилгүйдэл багасан, төсвийн орлого нэмэгдэнэ. Хөдөө аж ахуйг сэргээн босгох учраас тэдгээрийн бүтээгдэхүүний эрэлт ч ихэснэ. Хүн амын өсөлт нь зөвхөн байгалийн цэвэр өсөлтөөр төдийгүй Оросын бусад бүс нутаг, гадаадын орнуудаас ирж байгаа хүмүүсийн шилжих хөдөлгөөнөөс ч мөн нэгэн адил нэмэгдэнэ. Худалдаа, зочид буудлын бизнес, холбоо, нийтийн хоолны салбарууд эрчимтэй хөгжиж эхэлнэ.

Хамгийн өргөн шүүн хэлэлцэж байгаа нэг төсөл бол "Хятад дахь замын барилга байгууламж" юм. Түүний мөн чанар нь одоо үед Орос улс өөрийн Ази Номхон далайн чиглэлийн гадаад эдийн засгийн бодлогыг идэвхижүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байгаатай холбоотой бөгөөд Зүүн хойд Ази дахь олон талын хөрөнгө оруулалтын

хамтын ажиллагаанд хамаарах төслүүд болон Зүүн өмнөд Азийн (АСЕАН) улсуудын холбоотой улам нягт холбоо тогтоож байна. Үүнтэй холбогдож шинээр барих буюу урьд барьж байгуулсан аж үйлдвэрийн газруудыг шинэчлэн тоноглоход Оросоос тоног төхөөрөмж нийлүүлэхийг ихээхэн сонирхож байгаа нь Хятадтай хийх хамтын ажиллагаанд улам өргөн хэтийн төлвийг нээж байна. Гэвч тээврийн болон мэдээллийн дэд бүтэц сул хөгжсөн явдал үүний нэг бэрхшээлтэй тал юм.

Өнөөдрийн байдлаар Хятад руу гарах тээврийн гол гарц нь Оросын дорнод хэсэгт (Примор, Байгалийн цаадах) төвлөрсөн бөгөөд харин тээврийн баруун талын гарц нь Казахстаны нутгийг дайрч гардаг.

Орос Хятадын ерөнхий хил 54 км урттай хэсгийг бүрдүүлдэг бөгөөд энэхүү хэсэг нь Кош-Агачид байрладаг.

Хятадын хил орчмын газар нутаг нь Баруун Хятадын Шинжан Уйгарын өөртөө засах орон (ШУӨЗО) бөгөөд энэ нь БНХАУ хамгийн их талбай эзэлдэг (нутаг дэвсгэрийн 17 хувь буюу 1646 мян кв.км) нутаг юм. Энд 15 сая хүн аж төрдөг. Шинжан-Уйгарын нийслэл Урумчи хот 1.5 сая хүн амтай. ШУӨЗО орон их төлөв хөдөө аж ахуйг эрхэлдэг боловч нүүрс, нефть зэрэг олборлох салбарын, өнгөт ба хар төмөрлөг, хими, машин, эрчим хүчний үйлдвэрүүдтэй. Эдгээрт 200 гаруй төрлийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгддэг.

Өнөөдрийн байдлаар Орос, Хятадын хооронд байнгын тээврийн харилцааг зохион байгуулах дөрвөн хувилбар байдаг ба үүнд Орос, Хятад, Монгол, Казахстаны замын сүлжээг ашиглаж байна.

Мэргэжилтнүүд Кош-Агачаас Канас даваа хүртэл (ойролцоогоор 180 км) зам барих хувилбарт их ач холбогдол өгдөг. Тус төслийг хэрэгжүүлсэн нөхцөлд гуравдахь орныг алгасан Орос, Хятад улсад нэвтрэх авто замын хамгийн баруун чиглэлийн гарцтай болох бөгөөд зөвхөн хөрөнгө оруулалтын төдийгүй хамгийн дээд шатны улс төрийн дэмжлэг мөн шаардагдаж байгаа юм.

Хүснэгт 2

	Боломжууд /эерэг нөлөөлөл/	Аюул /сөрөг нөлөөлөл/	Зам барихад нөлөөлөх сөрөг үр дагаварыг арилгах арга хэмжээ
Ачаа тээвэрлэлт, зорчигч ба аялагчдын хөдөлгөөний хэмжээг нэмэгдүүлэх	Үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, үүнд: Худалдаа, зочид буудал, нийтийн хоол г.м Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх. Үүнд: тээвэр, холбооны салбарыг хөгжүүлэх, ажлын байрыг шинээр бий болгон орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх	Шилжин суурьшилтын өсөлтөөс экологид үзүүлэх нөлөөлөл, хар тамхины хэрэглээний өсөлт, халдварт өвчний өсөлт ба ДТП	Боловсон хүчин бэлтгэх ба дархан цаазтай газар нутгийг данслах, паспортжуулах

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийн эрэлтийг нэмэгдүүлэх	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх		
Ашигт малтмалыг хамтран эзэмших	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төсвийг өсгөж ард түмний орлогыг нэмэгдүүлэх	Хүн ам /ястан, үндэстэн/ уусах экологийн асуудлууд	Орон нутгийн боловсон хүчнийг сургах сонирхсон талууд байгалийн баялийг үр ашигтай ашиглах зөвлөл байгуулах
Дамжин өнгөрөх жуучлалыг хөгжүүлэх. Жнь: Алтайн мөнгөн тойрог	Худалдаа нийтийн хоол, орон нутгийн бэлэг дурсгалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдлыг урамшуулах		

Тухайн төслийн хамгийн эмгэг газар нь ЮНЕСКО-гаас амгалан бүс гэж зарласан Укокоор дамжин зам тавих явдал юм. Амгалан бүс болох "УКОК" бол Алтайн хязгаарт өөр адилтгах газаргүй, хамгаалалтанд байдаг шинэ объектуудын категори мөн.

Тус бүс нь хойч үедээ үлдээх байгалийн иж бүрдэл ба түүх угсаатны дурсгалт зүйлсийн нийлбэр цогц юм. Түүний зорилго нь одоо болон ирээдүйд шинжлэх ухааны судалгааны ажил хийхээр хамгаалалтанд авах, бүсийн орчин тойрон археологийн үнэт олдворуудад хор нөлөө үзүүлэхүйц үйл ажиллагаа явуулахыг хориглох ба хязгаарлалт тогтооход чиглэгдэнэ.

Амгалан бүсийн онцлог нь түүнд ховор ан амьтад, өвс ургамлууд байдаг. Одоогийн байдлаар Алтайн хязгаарын улаан номонд бичигдсэн 16 төрлийн ургамал, 30 төрлийн амьтад олдсон байна. Мөн археологийн олон тооны түүх дурсгалт зүйлсүүд олдсон.

Аялал жуучлалын салбар хөгжүүлэх, ашигт малтмал олборлох, Хятад улсад зам барих асуудлаар төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь орон нутгийн ард иргэдийн зүгээс дургүйцэл, эсэргүүцэлтэй тулгарч байна. Гэвч эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх нь орон нутгийн ард түмний амьдралд нэн чухал өөрчлөлтүүдийг гаргах юм.

Стратегийн төлөвлөлтийн хүрэн дэх нөлөөтэй (тэргүүлэх) эрдэмтдийн нэг болох И.Ансофф "Өөрчлөлт нь өнгөрсөн үеийн засаглалын зохион байгуулалт, бүтэц ба түүний соёлч байдалтай холбогдоогүй цагт эсэргүүцэл байнга гардаг. Стратегийн нэлээд өөрчлөлт нь зөвхөн төлөвлөлтийг эсэргүүцэх бус өөрчлөлтийн бүхий л хүрээг хамардаг. Эсэргүүцэл - зөвхөн хазайлт бус, харин суурь (фундаментал) асуудал бөгөөд стратегийг тодорхойлохоос багагүй анхаарал татах жамтай" гэж үзэж байна. Гэвч үндсэн дүгнэлтүүд компанийн төвшинд хийгддэг боловч тэдгээр нь тухайн бүсийн хэмжээнд ч хүчинтэй байдаг. Иймээс амжилттай хөгжихийн тулд "засаглалын бүх түвшний хөшүүргийг" албадлагын аргаар татан оруулах шаардлагатай. Эцэст нь

ЭДИЙН ЗАСАГ: онол, практик

албадлагын аргаар явуулсан өөрчлөлт тогтвортой бус байдаг ба компаниудын хуучин мөрдөж байсан уламжлалт аргатай зөрчилддөг.

Урт хугацааны тогтвортой стратегиар хангахад компанийн удирдлагын өөрчлөлтийг ашиглаж байх ёстой байдаг.